ГЭР ХОРООЛЛЫН ЦАХИЛГААН ХАЛААЛТ, НАМ ДАРАЛТЫН ЗУУХ БҮХИЙ АЙЛ ӨРХҮҮДЭД СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭР АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэр хорооллын цахилгаан халаалт, нам даралтын зуух бүхий айл өрхүүдэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглалтыг нэмэгдүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь аймгийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын айл өрхөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нэвтрүүлэх хөнгөлөлт үзүүлэх харилцааг зохицуулж, төвлөрсөн суурьшлын бүсийн утаа, агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, төвлөрсөн эрчим хүчний сүлжээний ачааллыг бууруулах, ногоон эрчим хүчний хэрэглээг дэмжихэд оршино.

1.2. Журам нь Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Эрчим хүчний сайдын 2026 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн А/42 дугаар тушаалаар (2026 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/169 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан) батлсан “Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам”, Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бусад холбогдох хууль тогтоомж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолд тус тус нийцсэн байна.

1.3. Журмыг аймгийн нутаг дэвсгэрт сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр (нарны цахилгаан систем болон түүнтэй хамт суурилуулсан батарей хуримтлуурын систем) шинээр нэвтрүүлсэн гэр хорооллын айл өрхөд хэрэглэнэ.

1.4. Журмыг хэрэгжүүлэх, хүсэлт хүлээн авах зэрэг бүх зохион байгуулалтын ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) зохицуулж, эрчим хүч хариуцсан байгууллага, сум дахь Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлнэ.

1.5. Журмыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, ил тод, шударга, адил тэгш хандах, зорилтот бүлгийг тэргүүн ээлжинд дэмжих зарчмыг баримтална. Орон нутгийн хөнгөлөлт нь Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон тарифыг орлохгүй, зөвхөн суурилуулалтын зардлыг хөнгөлнө. Сүлжээнд холбох техникийн шаардлагыг дээрх сайдын тушаалаар тогтоосонд нийцүүлнэ.

1.6. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.6.1. “тархмал эх үүсвэр” гэж хэрэглэгчийн байршилд суурилуулсан, нарны эрчим хүчээр цахилгаан үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг болон түүнтэй хамт суурилуулсан батарей хуримтлуурын системийг;

1.6.2. “хөнгөлөлт хүсэгч” гэж энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан айл өрхийг;

1.6.3. “суурилуулагч” гэж аймгийн Засаг даргын Тамгын газраас баталсан жагсаалтад багтсан, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах, тохируулах хуулийн дагуу тусгай зөвшөөрөл, мэргэшсэн туршлага бүхий компанийг;

1.6.4. “хөнгөлөлтийн хөрөнгө” гэж аймгийн төсөвт жил бүр тусгасан хөрөнгийг;

1.6.5. “суурилагдсан хүчин чадал” гэж нарны цахилгаан системийн инвертерийн нэрлэсэн нийт хүчин чадлыг кВт-аар илэрхийлсэн хэмжээг.

ХОЁР. ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭЛБЭР, ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМ

2.1. Хөнгөлөлтийг суурилуулалтын зардлаас нэг удаа, буцалтгүй хэлбэрээр, энэ журмын 2.2-т заасан хэмжээгээр үзүүлнэ.

2.2. Хөнгөлөлтийг дараах хүснэгтэд заасан хэмжээ, дээд хязгаараар тооцно.

№	Хөнгөлөлт хүсэгч	Системийн хүчин чадал	Хөнгөлөлтийн хэмжээ	Нэг системд олгох нийт дээд хязгаар (төгрөг)
1	Айл өрх	5 кВт хүртэл	1 кВт-д 1,750,000 төгрөг	8,750,000
2	Айл өрх	5 кВт-аас дээш, 10 кВт хүртэл (5 кВт-аас давсан хэсэгт)	1 кВт-д 1,050,000 төгрөг	14,000,000
3	Айл өрх	10 кВт-аас дээш, 20 кВт хүртэл (10 кВт-аас давсан хэсэгт)	1 кВт-д 700,000 төгрөг	21,000,000
4	Айл өрх	Нарны системтэй хамт суурилуулсан батарей хуримтлуур	Суурилуулалтын зардлын 20%, 1 кВт·ц-д 170,000 төгрөгөөс хэтрэхгүй	1,700,000 (10 кВт·ц хүртэлх багтаамжид)

2.2.1. Айл өрхөд олгох хөнгөлөлтийг хүчин чадлын шатлал бүрт тухайн шатлалд хамаарах хэсэгт тусад нь тооцно. Жишээлбэл 7 кВт системд 5 кВт×1,750,000 + 2 кВт×1,050,000 = 10,850,000 төгрөг олгоно.

2.2.2. Хүснэгтэд заасны дагуу тооцсон хөнгөлөлтийг, нэг системд олгох дээд хязгаарын хүрээнд, аймгаас суурилуулагчийн дансанд шууд шилжүүлнэ. Хөнгөлөлтөөс давсан гэрээний үлдэгдэл төлбөрийг хөнгөлөлт хүсэгч суурилуулагчид төлж, төлбөрөө баталгаажуулсан байна.

2.2.3. Хүснэгтийн 1-3-р мөрийн дүнг суурилуулалтын нийт өртөг 1 кВт-д 3,500,000 төгрөг, 4-р мөрийн дүнг батарей хуримтлуурын нийт өртөг 1 кВт·ц-д 850,000 төгрөг гэсэн жишиг өртгөөр тооцсон бөгөөд жишиг өртгийг жил бүр Засаг даргын захирамжаар эргэн харна.

2.3. Нэг хөнгөлөлт хүсэгчид нэг байршилд нэг удаа хөнгөлөлт олгоно. Өөр төсөл, хөтөлбөрөөс давхар санхүүжилт авсан бол давхардсан хэсгийг хасч тооцно.

2.4. Хөнгөлөлтийн хөрөнгийн эх үүсвэр нь аймгийн орон нутгийн төсөв байна.

2.5. Жил бүрийн хөнгөлөлтийн хөрөнгийн нийт хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийн төсөвт тусгана.

2.6. Хөнгөлөлт хүсэгч суурилуулагчтай суурилуулалтын гэрээ байгуулж, гэрээгээр хүлээсэн өөрийн төлөх хэсгийг бүрэн төлсөн байна. Ажлын хэсэг хүсэлтийг хянаж, энэ журмын шаардлагыг хангасан гэж үзвэл хөнгөлөлтийн хэмжээг баталгаажуулж, суурилуулалтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоно. Суурилуулагч суурилуулалтыг гэрээнд заасан нөхцөлийн дагуу бүрэн гүйцэтгэж, ажлын хэсэг хүлээн авсны дараа хөнгөлөлтийг суурилуулагчийн дансанд шилжүүлнэ.

2.7. Тоног төхөөрөмж нь стандарт, чанарын шаардлага хангасан, 5 жилээс доошгүй баталгаат хугацаатай байна. Суурилуулагч гэрээнд заасан хугацаанд суурилуулалтыг дуусгаж, 3.3-т заасан баримт бичгийг ажлын хэсэгт ирүүлнэ. Суурилуулагч үүргээ биелүүлээгүй, эсхүл суурилуулалт шаардлага хангаагүй бол хөнгөлөлт олгохгүй бөгөөд хөнгөлөлт хүсэгчийн төлсөн төлбөрийг суурилуулагч гэрээний дагуу буцаан олгоно.

2.8. Хөнгөлөлт нь суурилуулагчтай байгуулсан гэрээнд заасан үүсгүүр, инвертер, батарей, ухаалаг тоолуур, суурилуулалт, холболттой холбогдсон зардлаас хэтрэхгүй. Түгээх сүлжээнд нийлүүлсэн илүүдэл цахилгааны төлбөрийг хангагч нь тарифаар сар бүр олгодог тул хөнгөлөлтөд оруулахгүй.

2.9. Суурилуулагчаас үнэгүй олгосон, үнийн буулт, урамшууллаар олгосон тоног төхөөрөмжийн хэсгийг хөнгөлөлтийн тооцооноос хасна.

2.10. Үүсгүүр, инвертер, тоолуур болон бусад дагалдах төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах, түгээх сүлжээнд холбохтой холбогдон гарах зардлыг Эрчим хүчний сайдын А/42 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.4.3-ын дагуу хөнгөлөлт хүсэгч хариуцах бөгөөд энэ журмын дагуу олгох хөнгөлөлт нь тухайн зардлын зөвхөн 2.2-т заасан хэсгийг нөхнө.

ГУРАВ. ХӨНГӨЛӨЛТ ХҮСЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

3.1. Хөнгөлөлт хүсэгч дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын хашаа байшинд оршин суугаа иргэний өрх байх;

3.1.2. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй бөгөөд гэр, сууцныхаа халаалтаа цахилгаан халаагуур, нам даралтын зуух эсхүл тэдгээртэй адилтгах бусад халаалтын төхөөрөмжөөр шийдвэрлэсэн байх;

3.1.3. Эх үүсвэрийг энэ журам хүчин төгөлдөр болсноос хойш шинээр суурилуулж, ашиглалтад оруулсан байх;

3.1.4. Суурилуулсан газар нь өмчлөл, эзэмшил, ашиглалтын хууль ёсны эрхтэй, газрын маргаан, зөрчилгүй байх;

3.1.5. Систем нь Эрчим хүчний сайдын А/42 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу түгээх сүлжээнд холбогдох байх;

3.1.6. Суурилагдсан хүчин чадал нь 20 кВт-аас ихгүй, 0.22 кВ-ын холболтод холбогдох нарны үүсгүүрийн хувьд 12 кВт-аас ихгүй байх;

3.1.7. Тоног төхөөрөмж Эрчим хүчний сайдын А/42 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.7-д заасан олон улсын стандартын шаардлагыг хангасан байх;

3.1.8. Суурилуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газраас баталсан суурилуулагч компанийн жагсаалтад багтсан, ТЗ-1.1 эсвэл ТЗ-2.1 тусгай зөвшөөрөл бүхий суурилуулагч гүйцэтгэсэн байх;

3.1.9. Тоног төхөөрөмж шинэ, ашиглаагүй байх бөгөөд анх удаа суурилуулсан байх. Одоо байгаа системийн өргөтгөл, хуучин тоног төхөөрөмж энэ журмаар хөнгөлөлт олгохгүй.

3.2. Хөнгөлөлт хүсэгч хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

3.2.1. Иргэний үнэмлэхийн хуулбар;

3.2.2. Оршин суугаа газрын хаяг, ам бүлийн тодорхойлолт;

3.2.3. Газрын өмчлөл, эзэмшлийн гэрчилгээ, кадастрын зураг (e-gazar.gov.mn);

3.2.4. Халаалтын хэлбэр, төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй болохыг баталгаажуулсан баримт бичиг;

3.2.5. Баталсан жагсаалтад багтсан суурилуулагчтай байгуулсан суурилуулалтын гэрээ. Гэрээнд системийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч, марк, гэрээний нийт үнэ, энэ журмын дагуу олгох хөнгөлөлт,

хөнгөлөлт хүсэгчийн төлөх хэсэг, суурилуулалт дуусгах хугацаа, баталгаат хугацааг тус тус заасан байна;

3.2.6. Хөнгөлөлт хүсэгчийн төлөх хэсгийг суурилуулагчид төлсөн төлбөрийн баримт (банкны шилжүүлэг, кассын баримт).

3.3. Суурилуулагч суурилуулалтыг дуусгасны дараа дараах баримт бичгийг ажлын хэсэгт ирүүлнэ:

3.3.1. Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холболтын акт болон хөнгөлөлт хүсэгч суурилуулалтыг хүлээн авсан тухай акт;

3.3.2. Суурилуулсан хүчин чадлын тодорхойлолт, фото зураг;

3.3.3. Тоног төхөөрөмжийн стандартын гэрчилгээ.

3.4. Бүрдэл дутуу бол 10 ажлын өдрийн дотор нөхөх хугацаа олгоно.

3.5. Хөнгөлөлт дараах дарааллаар олгогдоно:

3.5.1. Хөнгөлөлт хүсэгч аймгийн Засаг даргын Тамгын газраас баталсан суурилуулагч компанийн жагсаалтаас аль нэг компанитай суурилуулалтын гэрээ байгуулна;

3.5.2. Хөнгөлөлт хүсэгч гэрээгээр хүлээсэн өөрийн төлөх хэсгийг суурилуулагчид төлж, төлбөрийн баримтыг ажлын хэсэгт ирүүлнэ;

3.5.3. Ажлын хэсэг хөнгөлөлт хүсэгчийн ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянаж, энэ журмын шаардлагыг хангасан эсэхийг тогтоон, хөнгөлөлт олгох боломжтой тухай шийдвэрийг хөнгөлөлт хүсэгч болон суурилуулагчид мэдэгдэж, суурилуулалтын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоно;

3.5.4. Суурилуулагч гэрээнд заасан хугацаанд суурилуулалтыг дуусгаж, 3.3-т заасан баримт бичгийг ажлын хэсэгт ирүүлнэ;

3.5.5. Ажлын хэсэг тоног төхөөрөмж, суурилуулалтын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж, хүлээн авсан тухай акт үйлдэнэ;

3.5.6. Ажлын хэсэг хүлээн авсан акт болон 3.3-т заасан баримт бичгийг үндэслэн хөнгөлөлтийг суурилуулагчийн дансанд шилжүүлэх саналыг аймгийн Засаг даргад гаргаж, шийдвэрийн дагуу шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1. Хөнгөлөлт хүсэгчийн эрх, үүрэг:

4.1.1. Хүсэлт, бүрдүүлсэн мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцах;

4.1.2. Эх үүсвэрийг стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн ашиглах;

4.1.3. Хөнгөлөлттэй суурилуулсан системийг 5 жилийн дотор өөр этгээдэд шилжүүлэхгүй байх;

4.1.4. Хяналт шалгалтад хамтран ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт бичгээр хангах.

4.2. Ажлын хэсгийн эрх, үүрэг:

4.2.1. Хүсэлтийг хүлээн авч, бүрдлийг шалгаж, ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэх;

4.2.2. Журмын хэрэгжилт, хөнгөлөлтийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг ил тод байлгаж, жилд хоёр удаа аймгийн Засаг даргад тайлагнах;

4.2.3. Хамтран ажиллах суурилуулагч компанийн жагсаалтыг бэлтгэж аймгийн Засаг даргын Тамгын газраар батлуулах, бүртгэл хөтлөх;

4.2.4. Хөнгөлөлтийг суурилуулагчийн дансанд шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.5. Суурилуулалтыг газар дээр нь шалгаж, хүлээн авсан тухай акт үйлдэх;

4.2.6. Хөнгөлөлтийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах;

4.2.7. Хөнгөлөлт хүсэгчид техникийн зөвлөгөө, мэдээлэл өгөх.

4.3. Суурилуулагч, нийлүүлэгчийн эрх, үүрэг:

4.3.1. Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах;

4.3.2. Баталгаат хугацаанд засвар үйлчилгээг хариуцах;

4.3.3. Худалдаа, суурилуулалтын баримт бичгийг үнэн зөв олгох;

4.3.4. Түгээх сүлжээнд холбох бүх ажлыг (хялбаршуулсан хүсэлт гаргах, шалгах хуудас бөглөж баталгаажуулах, холбуулах хүсэлт хүргүүлэх) Эрчим хүчний сайдын А/42 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хөнгөлөлт хүсэгчийн өмнөөс гүйцэтгэх, түгээх сүлжээ хүчдэлгүй болсон үед үүсгүүрээс сүлжээнд хүчдэл өгөхгүй төхөөрөмж суурилуулах;

4.3.5. Гэрээнд хөнгөлөлт хүсэгчийн төлөх хэсэг, энэ журмын дагуу олгох хөнгөлөлтийн хэмжээг тодорхой заах бөгөөд хөнгөлөлт хүсэгчээс гэрээнд заасан хэмжээнээс илүү төлбөр шаардахгүй.

4.4. Түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг:

4.4.1. Хялбаршуулсан хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж, холбох шалгалтыг ажлын 3 өдрийн дотор хийж, сүлжээнд холбох ажлыг Эрчим хүчний сайдын А/42 дугаар тушаалаар батлагдсан журамд заасан хугацаанд гүйцэтгэх;

4.4.2. Тоолуур суурилуулах, хяналт тавих, зөвлөгөө өгөх;

4.4.3. Хөнгөлөлт хүсэгчийн системээс түгээх сүлжээнд нийлүүлсэн илүүдэл цахилгаан эрчим хүчний төлбөрийг гэрээний дагуу сар бүр тооцож олгох.

ТАВ. ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ, ХАРИУЦЛАГА

5.1. Хөнгөлөлт авсан эх үүсвэрийн ашиглалт, зориулалтын дагуу байгаа эсэхэд ажлын хэсэг жилд нэг удаа удаа хяналт тавина.

5.2. Хөнгөлөлт хүсэгч худал мэдээлэл, баримт өгч хөнгөлөлт авсан, эсхүл зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдвол олгосон хөнгөлөлтийг хөнгөлөлт хүсэгчээс, суурилуулагч үүргээ биелүүлээгүй бол суурилуулагчаас буцаан гаргуулж, хөнгөлөлтийн хөрөнгөд эргүүлэн төвлөрүүлж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3. Журмын хэрэгжилтийн үр дүнг (суурилуулсан хүчин чадал, хэмнэсэн эрчим хүч, бууруулсан ялгарал, хөнгөлөлт авсан айл өрхийн тоо, хөнгөлөлтийн хөрөнгийн зарцуулалт) жил бүр тайлагнана.

5.4. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.5. Сүлжээнд холбох, цахилгааны төлбөртэй холбоотой маргааныг Эрчим хүчний зохицуулах хороо, аймгийн зохицуулах зөвлөл шийдвэрлэнэ. Хөнгөлөлттэй холбоотой маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

----o0o----